



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/107

Чойр

Ажлын хэсэг томилох тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 4.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог батлах тухай” А/13 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсонтой холбогдуулан байгууллагын чиг үүргийн болон ажлын байрны шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

М.Анхбаяр

(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

С.Уранцэцэг

(Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Н.Батцэцэг

(Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

Б.Нэргүйцэцэг

(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Г.Хонгор

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

У.Занабазар

(Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Г.Дашжаргал

(Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

В.Баярсайхан

Нарийн бичгийн дарга:

(Нийтлэг үйлчилгээний албаны менежер)

Д.Оюунсайхан

(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

2. Албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журмын дагуу 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.СОДНОМ

